


БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ПАЗРЫН ДАРГА



2024 оны ~~С~~дугаар сарын
02-ны өдөр

ОЛОН УЛСЫН ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ
MNS ISO 9001:2016 СТАНДАРТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙЛГЭХ
АЖЛЫН ДААЛГАВАР

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Захиалагч

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

2. Үндэслэл

Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйл, Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын 5.2.4, 5.4.15 дахь зүйл, Засгийн газрын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5.4.5 дахь зүйл, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр бүлэг (засаглалын бодлого) -ийн 4.2.1, Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 181, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн "Нийслэлийн хэмжээнд засаглалын үзүүлэлтийг тооцох, чанарын удирдлагын тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартын баталгаажуулах ажлыг зохион байгуулах тухай" А/1041 дугаар захирамжийг тус тус үндэслэнэ.

3. Зорилго

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд олон улсын чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх ажил нь сайн засаглалыг хөгжүүлэх, цахим засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэх, дотоод удирдлага хяналтын тогтолцоог сайжруулах зорилгын хүрээнд хэрэгжүүлж байгаа болно.

MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлснээр нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны зохион байгуулалттай, төрийн үйлчилгээний чанар, гүйцэтгэлийн үр дүн, хяналтын тогтолцоо сайжирна. Энэ нь нутгийн захиргааны байгууллагуудын хариуцлагатай, нээлттэй, сайн засаглалыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Б. АЖЛЫН ДААЛГАВАР

Олон улсын чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартын баталгаажуулалт хийлгэх ажлын хүрээнд хийгдэх үндсэн үйл ажиллагааны жагсаалтыг дараах хүснэгтэд харуулав.

1. Байгууллагын алба хаагчдад MNS ISO 9001:2016 стандартын болон дотоод аудитын сургалт зохион байгуулах
2. Байгууллагад дотоод аудитын үйл ажиллагаа явуулах, дүн шинжилгээ хийж баримтжуулах, сайжруулах
3. Үл тохирлыг илрүүлж, залруулах, сайжруулах арга хэмжээ авах
4. MNS ISO 9001:2016 стандартын баталгаажуулалт хийлгэх бэлтгэл ажлыг хангах
5. Өөрийн зардлаар MNS ISO 9001:2016 стандартын баталгаажуулалт хийлгэх

В.ЦАГ ХУГАЦАА БА ТАЙЛАН

Зөвлөх үйлчилгээний байгууллага нь үнэлгээг хийх ажлын хүрээнд дараах бүтээгдэхүүнийг захиалагч байгууллагад гаргаж өгнө. Үүнд:

Зөвлөх үйлчилгээний байгууллага нь тус ажлыг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор багтаан хийж дуусгах ба үнэлгээ дууссанаас хойш ажлын 2 хоногт багтаан хураангуй тайланг, ажлын 3 хоногт багтаан дэлгэрэнгүй тайлан хүлээлгэн өгөх бөгөөд үнэлгээний ажлын хүрээнд дараах бүтээгдэхүүнийг захиалагч байгууллагад гаргаж өгч баталгаажуулалт хийлгэнэ. Үүнд:

#	Гол бүтээгдэхүүн	Тодорхойлолт	Дуусгах хугацаа
1	Эхлэлийн тайлан	Нарийвчилсан ажлын төлөвлөгөө.	Гэрээ байгуулагдсан хугацаанаас долоо хоногийн дараа
2	Явцын тайлан	Нарийвчилсан ажлын төлөвлөгөө зэргийг тусгасан байна.	Гэрээ үргэлжлэх нийт хугацааны дунд долоо хоногт
3	Урьдчилсан тайлан	Урьдчилсан тайлан нь арга зүй үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж зэргийг багтаасан байна. Урьдчилсан тайланд захиалагч байгууллагаас санал авч, сайжруулах ажил гүйцэтгэнэ.	Гэрээ дуусах хугацаанаас 2 долоо хоногийн өмнө
4	Эцсийн тайлан	Захиалагч байгууллагаас авсан саналыг тусган тайланг эцэслэж, хэвлэмэл болон файл хэлбэрээр хүлээлгэж өгнө.	Гэрээ дуусах хугацааны сүүлийн долоо хоногт
5	Явцын мэдээ	Явцын товч тайлан	7 хоног тутам